

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Намсрайн Гүрбадам	Дугаар	L101
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Жаргалтхаан сум
Төрсөн газар	Жаргалтхаан сум	Төрсөн он	1934
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Уугийн хурал	Сүм хийдийн дугаар	ХЭЖХ 014
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 14	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Уугийн хурал

-Таныг Уугийн хурлын талаар сайн мэднэ гэсэн сургаар явж байна. Танай хүү чинь хамт явж үзүүлж байсан, очоод асуу даа гэсэн юм.

-Хэдэн дугантай хэр олон ламтай байсан юм болоо?

Яахав дээ хоёр дугантай, тийм олон ламтай байгаагүй ээ. 20-иод ламтай байсан байх. Бага хурал байсан ш дээ.

-Гэр дуганы хажууд бас нэг дуган байсан юмуу? Бөөрөнхий? Түүр нь байсан. Дотроо багана энэ тэр байсан болов уу гэмээр байсан.

Бүрээний 4 шатны мод байсан гаргачихсан юм байгаа биз дээ.

-Би хараад бүрээ энэ тэр тавьдаг болов уу гэж бодсон. Бүрээ зүүн урдаа байсан байна лээ. Баруун хойноо юу байсан юм бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тэр чинь Бадарын эцгийн хурал, дуган байсан. Лүн Нуваан гэдэг хүн байсан. Лүн Нувааны хурал.

-Гол дуганы дөрвөн чулуу байсан. Тэр юу вэ?

Зүгээр хуучин суурь нь.

-Нийт хоёр дуган байсан юмуу? Өөр дуган байсан уу?

Байсаан. 20-иод ламтай байсан байх.

-Яг хэдэн онд байгуулагдсан юм болоо?

Би мэдэхгүй.

-Нураагдсан он, хаагдсан он нь хэзээ байсан юм бол?

1937 оны хавьцаа л байх.

-Та яг тэр Уугийн отгийн хавийн хүн үү?

Тийм. Тэр чинь хойшоо Шиврийн хурлаас тусдаа гарсан хурал шүү дээ.

-Шиврийн хурлаас тасарсан хурал байх нь ?

Шивэр чинь Тойны отгийн хурал. Бугын тэнд байсан. Тойн лам юм хүм мэддэг мундаг хүн байсан юм. Лүн Нуваан гэдэг чинь сайн хүн. Бор Наваан гэдэг нь эмч, маарамба хүн байсан.

-Энэ Лүн Нуваан гэж Цэрэндорж гуайн ярьж байсан Нуваан гэлэн юм болов уу?

Баригдсан баригдсан. Бүгд хоригдсон. Дулаан хааны энд буудуулсан.

-Дулаан хаан гэж хаана байсан юм бэ?

Өндөрхааны энд. Тэнд л ихэнх лам нарыг хороосон. Тэр хойно нь нэг толгой байгаа биз дээ. Тэнд бумба дарсан.

-Лусын бумба дарсан уу?

Мэдэхгүй юутай юм дарахад л дарсан.

-Хийдийнхээ баруун хойшоо юу?

Чанх хойно нь.

-Хүүхдийн овоо гэсэн байсан тэрийг?

Хүүхдийн овоо нь тэр дор шүү дээ.

-Хүүхдийн овооны дээшээ юм уу?

Тийм.

-Хүүхдийн овоог бас буулгаад доор нь байсан юм хумыг аваад явсан юм шиг байна лээ?

Үгүй ээ энэ улсууд ухчихсан юм. Уг нь ухаагүй байсан юм.

-Цаана нь бас нэг чулуу овоолчихсон байсан. Хүүхдийн овооны баруун хойд талд?

Бумбыг л хайсан юм байгаа биз. Тэгж л таарах байх.

-Өөр та энэ хавиас Уулын отгийн хурлаас өөр мэдэж байгаа юм байна уу?

Мэдэхгүй ээ.

-Уртын хурал гэж байсан байна л даа?

Аан тийм хамбын отгийн хурал буюу мэргэн хамбын хурал.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тахилтын хурлын отог нь юу гэдэг байсан юм бэ?

-Жаал номун хаан л гэж байсан юм гэсэн. Отог нь юу гэдэг байсныг мэдэхгүй. Тэр чинь Зүүн баяны хийдэд сууж байсан.

-Зүүн баяны хийд чинь Хүүхэн хутагтын хийд үү?

Тийм тэнд сууж байсан.

-Хойшоо Алтан тусгал гэсэн байхаа мөрний тийшээ Цагаан суварга гэж байсан.

Тийм байсан. Бараг Жаргалтхааны нутаг, залгаа байдаг.

-Уугийн отгийн талаар таны өөр хуучцуулаас сонсож байсан юм байна уу? Лам нарынх нь тухай ч юмуу.

Би сонссон юмгүй ээ. Тэр хоёр хүн байна. Тэгээд жижиг лам нар зөндөө л байсан байх.

-Жилийн 4 улиралдаа хурдаг байсан үү?

Тийм.

-Дэндэв гуайн багшийг мэдэх үү?

Өнө ваны Цэнгэл үү, Шиврийн хурлын Лувсанцэрэн лам хоёрын л нэгийх байх. Миний багш тэр гэж хэлдэг хүн байгаагүй. Галсанцэрэн лам чинь л Шиврийн шүтээний ганц мэддэг хамба лам нь байсан юм.

-Уугийн хурлын хамба лам нь Лүн наваан байсан уу?

Тийм. Их үнзад нь Дэндэв гуай байсан. Бага үнзад нь манай ах Жадарамба байсан.

-Цорж лам нь хэн гэдэг хүн байсан бэ?

Иш гавж гэж байсан. Бас л баригдаад явсан. Гэхдээ эргээд ирсэн юм.

-Таалал болсон он нь 40, 50-аад он үү?

Үгүй саяхан.

-Гэсгүй лам нь ямар хүн байсан юм бол?

Ёстой мэдэхгүй. Тэр талаар асууж байгаагүй.

-Лам нарынх нь байр энэ тэр бүгд байсан байх даа тэ?

Дуганаас зүүн хойш хэдэн чулуу байгаа. Тэр чинь гал зуух нь. Тэрийг сайн мэднэ. Хонь хариулж байхдаа гэр гэж тоглодог байсан.

Жижигхэн чулуу байгаа биздээ. Тэрэн дээр би найзтайгаа хамт тоглодог байлаа.

-Зэрэгцээ дугуйны бүр том багана энэ тэртэй байсан түүрх байна. Тэр гэр байсан юм болов уу? Модоор барьсан гэр дуган байсан юм болов уу?

Гэр дуган л байсан юм. Хоёр баганы суурь байна уу?

-Байна лээ. Цаад талдаа хоёр баганы суурьтай, бүр 4 ч баймаар модтой юм байна лээ. Гэр түүринаасаа баруун хойшоо тэр нэг дуган нь байхуу тэ? Гэр дуганыхаа зэрэгцээ бас нэг түүрх байсан тэр юу байсан юм бол?

Ойрхоон. Нэг хашаа байсан. Зүүн талд нь 7x8 ын харьцаатай юм байсан.

Тэрийг би мэдэхгүй.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Гэр дуганыг тойрсон хашаа байсан юм шиг байгаа юмаа. 40х40 –ын харьцаатай байсан. Бүрээ шатныхаа цаагуур тойроод. Тийм юм байхлаар нь хашаа бүрээ гэж бодсон.

Мэдэхгүй ээ. Дуганы хойд талд Буга гэж нэг том хар уул байгаа. Тэндээс үхэр тэргээр авчирч байсан гэдэг. Халзан Гэлэн, толгой Шарав гэж нэг хүн байсан. Тэр хоёр тэнхээтэй хүн ачиж байсан гэсэн.

-Хэдэн оны үеэр юм бол оо?

Анхан дуган байгуулагдах үеэр.

-Толгой Шарав гэдэг хүн чинь хэдэн оны үед байсан бэ?

Хувьсгалын үед байсан уу?

-Тэгвэл тэр хүн дуганы модонд явж байсан гэдэг чинь хэр настай байсан бэ?

Настай байсан.1900-аад оны эхэн үеэр л төрсөн байх.

-Тэгэхээр Шиврийн хурлаас тасарсан гэхээр байж болох л юм байна л даа.